МЭДЭЭ · 2023 оны 8-р сарын 29

ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГДЭХЭД НӨЛӨӨЛСӨН ШАЛТГААН, НӨХЦӨЛИЙГ АРИЛГУУЛАХААР 10 БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД МЭДЭГДЭЛ БИЧИЖ ХҮРГҮҮЛЛЭЭ



Прокурорын байгууллага 2023 оны 8 дугаар сарын 21-нээс 25-ны өдрүүдэд мөрдөгч болон эрх бүхий албан тушаалтанд тодорхой ажиллагаа гүйцэтгүүлэхээр 414 даалгавар бичгээр өгч, эрүүгийн болон зөрчлийн хэрэг бүртгэх, ял эдлүүлэх ажиллагааг хэрэгжүүлэх явцад гарсан зөрчлийг арилгуулахаар харьяа байгууллагуудад 3 шаардлага хүргүүллээ.

Мөн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар 10 байгууллага, албан тушаалтанд мэдэгдэл бичсэн байна. Тухайлбал:

Сонгинохайрхан дүүргийн прокурорын газраас тус дүүргийн ерөнхий боловсролын дугаар сургуулийн сурагчид сургуулийн хашаан дотор хоорондоо маргалдан, бие биедээ халдаж эрүүл мэндэд нь хөнгөн хохирол учруулсан гэх асуудалд сурагчдад чиглэсэн эерэг нөлөөллийн ажил, арга хэмжээг зохион байгуулах, хууль тогтоомжийн талаар мэдээ, мэдээлэл өгөх зэрэг ажлыг хийлгүүлэхээр сургуулийн захиргаанд;

Дархан-Уул аймгийн прокурорын газраас Хонгор сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн ажлыг шалгаад сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой төлөвлөх, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, согтуурахтай тэмцэх тухай болон хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, гэмт хэрэг, зөрчил гарахад нөлөөлж буй шалтгаан нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авхуулахаар тус тус прокурорын мэдэгдэл бичиж хүргүүлжээ.

Прокурорын мэдэгдлийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан тухайн зөрчил, гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээ авч, 1 сарын дотор бичгээр хариу өгөх үүрэгтэй.

Видео: https://www.youtube.com/watch?v=1bs7iDuoq58

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1612